



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТҮҮХ

Тус аймагт статистикийн алба үүсч хөгжсөн нь аймгийн эдийн засаг нийгмийн хөгжийн түүхтэй салшгүй холбоотой юм. Хувьсгалаас өмнө бүртгэлийн ямар нэгэн байгууллага байгаагүй бөгөөд шинэ нийгмийн анхны шатанл **НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТОЛЬ БОЛСОН СТАТИСТИКИЙГ** хөгжүүлэх нь туйлын чухал зорилт болон тавигдаж байлаа.

1992 онд 7 дугаар сард хуралдсан засгийн газрын 29 дүгээр хурлаас хүн ам, малын тооллого явуулах бүртгэлийн маягт хүснэгт боловсруулах, зарим мэдээ авч нэгтгэх ажлыг төвлөрүүлэн удирдах тоо бүртгэх байгууллагыг дотоод яаманд байгуулах асуудлыг хэлэлцээд улс даяар тоо бүртгэх ажил нэн чухал байгааг тэмдэглэж, цаашид уг асуудлыг нутгийн захиргаа байгуулахтай хамтатган шийдэх нь зүйтэй гэж тогтжээ. Ингэснээр орон нутагт статистикийн алба үүсч хөгжих эхлэл тавигдсан юм.

1931 онд аймагт байгуулагдан төрийн албадууд орон нутагт бий болж 1938 оноос 1960 он хүртэл тоолж бүртгэх, улмаар төлөвлөх байгууллагууд хамтдаа ажиллаж байлаа.

1960 оны 7 сарын 1-нд аймгийн төлөвлөгөөний комиссоос салган тоо бүртгэлийн товчоо байгуулж дарга, ахлах тоо бүртгэгч, нийгэм хангамж, эрүүлийг хамгаалах, соёл, хүн ам эрхэлсэн тоо бүртгэгч, ХАА-н салбар эрхэлсэн тоо бүртгэгч, аж үйлдвэр барилга, тээвэр, холбоо эрхэлсэн тоо бүртгэгч гэсэн 5 орон тоотойгоор байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд тоо бүртгэлийн товчооны анхны дарга нь Д.Лхамжав, ахлах тоо бүртгэгч нь Г.Цэрэнжээ нар байсан байна.

1935 оноос хүн амын болон малын тооллого, судалгааг явуулж байсны баримт болж аймгийн хүн ам 1935 онд 46.3 мянга, 1944 онд 46.9, 1956 онд 46.9, 1963 онд 51.1 мянгаар, мал сүргийн тоо 1933 онд 2.4 сая, 1941 онд 1.8 сая, 1950 онд 1.4 сая, 1960 онд 1.4 сая-аар тус тус тоологдож бүртгэгдсэн байдаг.

Тус алба нь байгуулагдсан цагаасаа эхлэн нийгэм, эдийн засгийн амьдралын бүхий л хүрээг хамарсан мэдээллийг бий болгох, түүнийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох, мэдээлэгч нарт эзэмшүүлэх, тооцоо судалгаа хийж, нэгтгэн танилцуулж байхыг эрхэмлэн зорьж ирсэн билээ.

Түүхэндээ статистикийн алба 1935. 1944. 1956. 1963. 1969. 1979. 1989, 2000, 2010 оны хүн амын тооллогуудыг зохион байгуулан явуулж дүнг нэгтгэн тооцож ирсэн байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцад түүнийг таниж мэдэх үзүүлэлтүүд нэмэгдэхийн хирээр нэг удаагийн тооллого судалгаа шаардлага хангахгүй болж улмаар жил улирал сарын мэдээнүүд бий болж богино хугацаанд олон мэдээлэл авах

шаардлагыг статистикийн байгууллагын өмнө тавьж үүний дүнд эдийн засаг нийгмийн хөгжлийн талаархи асар олон мэдээллийг цуглуулж ирсэн байгаа юм.

Мэдээ, мэдээлэл нэмж бий болохын хирээр орон тоо нэмэгдэж 1980-1988 онуудад 11-12 хүнтэй хэлтэс болон ажиллаж УААА-н бүх салбаруудыг хамруулсан маш их мэдээллийг төвлөрүүлэн цуглуулж төлөвлөсөн үзүүлэлт бүрийн биелэлтийг он тус бүрээр болон 5 жилээр тооцон гаргаж байлаа.

Статистикийн ажлын салшгүй нэг хэсэг нь мэдээллийг богино хугацаанд боловсруулах, үр дүнг тархааж танилцуулах ажил байдаг. Энэ хүрээнд мэдээллийн программ хангамжийн асуудал, статистикийн төв байгууллагад түргэн шуурхай, алдаа багатай дамжуулж авах техник хэрэгслийн асуудал багтаж ирсэн. Төр, засгаас анхаарч бэхжүүлж ирсний дүнд гараар бичиж, бүх үйлдлийг орос болон хятад сампин, жижиг тооны калькулятороор хийж танилцуулдаг байсан бол 1965 онд бичээч операторчны орон тоотой болж бичгийн машинаар бичиж танилцуулах алхам руу орсон юм.

Статистикийн төв байгууллагад мэдээг дамжуулахдаа шуудангаар голчлон явуулах аргыг хэрэглэж ирсэн бөгөөд сарын болон улирлын шуурхай мэдээллүүдийг холбооны газрын телетайп аппаратыг ашиглан дамжуулж мөн утсаар 2-3 цаг мэдээгээ уншиж дамжуулдаг байлаа. Энэ байдал 1983 оныг хүртэл үргэлжилсэн бөгөөд тооцоолох техникийн анхных болох мэдээллийг зохих программын дагуу боловсруулдаг, төвд дамжуулдаг хэвлэх үүрэг бүхий МЕРА-100 тооцоолох машиныг авч ирж суурилуулснаар орон нутагт тооцоолох техник хөгжих үндсийг тавьсан бөгөөд анхны инженер – программист гэсэн орон тоонд В.Занашир ажиллаж байсан юм. МЕРА-100 машинаар анх удаа мал тооллогын дүнг боловсруулж шалгаж нэгтгэл хийж байсан нь тухайн үедээ ажлыг асар ихээр хөнгөвчилж байсан. 1988 онд компьютер техникийн анхных болох МОНЕЛ компьютерийг улсаас хөрөнгө оруулалтаар өгч үүний дараа ШАРП хувилах хэрэгслээр хангасан нь статистикийн албадын ажлыг хөнгөвчлөхөд ихээхэн тустай болсон. Анхны компьютер, хувилагч хэрэгслэлийг ажиллуулдаг, инженер программист нь ОХУ-д дээд боловсрол эзэмшсэн, Ц. Соёмбо байлаа. **Ер нь 1970. 1980. 1990-ээд онуудад тооцоолох техник хэрэгслийн хөгжлийг орон нутагт статистикийн байгууллагууд тодорхойлж, авч явж ирсэн, энэ утгаараа Увс аймаг дахь анхны тооцоолон бодох техник, хэрэгслэлүүд түүнд ажиллагсад анхны инженерүүд байлаа.**

Хөгжлийн явцад өндөр хурдтай техник хэрэгсэл гарч ирснээр өмнөхөө халж 386. 486. 586 гэсэн процессортой компьютерүүдийг авч ашиглах шаардлага нэмэгдэж байснаар 1995-2000 онуудад тухайн үеийн аймгийн засаг дарга, ТСЭЗБ-ын хэлтсийн дарга нарын дэмжлэгээр техник хэрэгслүүдээ бүрэн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлж ажиллаж байлаа.

1990-ээд оны эхэн хүртэл эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жилийн болон 5 жилийн төлөвлөгөөний биелэлтүүдийг нэг бүрчлэн гаргаж баталгаажуулдаг алба байлаа.

Нийгмийн нэг хэвшлээс нөгөөд шилжиж буй шилжилтийн энэ он жилүүдэд /1990-2000/ статистикийн албаны үүрэг зорилт үндсээрээ өөрчлөгдсөн гэж хэлж болно. Юуны өмнө Монгол улсад анх удаагаа гарсан Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэн эдийн засаг, нийгмийн шинэ тогтолцоотой холбоотойгоор шинэ мэдээллийг бүрдүүлэх, ялангуяа хүн ам, нийгмийн үзүүлэлтүүдийг илүү дэлгэрэнгүй судлах ажлыг гол зорилго болгож тавьсан. Түүнчлэн урьд өмнө нь тооцдоггүй байсан гэхдээ нийгмийн харилцааг илэрхийлдэг олон үзүүлэлтүүдийг шинээр тооцдог болсон. Үүнд: ажилгүйдэл, ядуурал, инфляци, нэг өрхийн орлого, зарлага хэрэглээ зэргийг нэрлэж болох бөгөөд өмнө нь тооцож байсан нилээд олон үзүүлэлтүүдийн авах аргачлал, ангилал, тооцох зарчим зэргийг олон улсын стандарт ангилалд нийцүүлэх, олон улсын түвшинд зэрэгцүүлэхүйц түвшинд хүргэх ажлуудыг хийснээр статистикийн шинжлэх ухаан гэсэн тал руугаа илүү хандах болсон. Нэлэнхүй ажиглалтаар цуглуулдаг олон мэдээллийг түүвэр судалгааны арга руу шилжүүлж өрхийн орлого, зарлага, нэг хүнд ноогдох хүнсний гол нэрийн бүтээгдхүүн, хэрэглээний илчлэг, уураг болон ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаархи мэдээллүүдийг түүвэр судалгаагаар гаргаж танилцуулдаг болсон.

1997 оноос Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцээс салж Засаг даргын дэргэдэх хэлтэс болон байгуулагдсанаас хойш ЗДТГ –ын байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэн 10 жил тутамд хүн амын тооллого, 3 жил тутамд аж ахуйн нэгжийн тооллого, хагас, бүтэн жилээр малын тооллого зохион байгуулан явуулж улмаар жил тутам өрх, хүн амын бүртгэлд суурилсан хүн амын тоо, аймгийн ДНБ-ний тооцоо зэргийг шинэчлэн гаргаж сар, улирал, жилийн бюллетень танилцуулга боловсруулж цахим хэлбэрээр тархаах, интернетэд байршуулах, хэвлэмэл байдлаар хүргэх зэргээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилж байна. Түүнчлэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажил эрхлэлтийн судалгаа, “ Цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж байгаа байдал”, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа зэрэг түүвэр судалгаануудыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, хүн ам, орон сууцны, ХАА-н, аж ахуйн нэгжийн тооллого зэрэг тооллого, түүвэр судалгааг ҮСХ-ы аргачлал зааврын дагуу зохион байгуулан явуулж үр дүнг тархаан танилцуулж байна.

Түүнчлэн аймгийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг олон жилээр, сумчлан боловсруулж эмхэтгэл, танилцуулга хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, аж ахуйн нэгж байгууллагуудын регистрийн сан байгуулж мэдээлэл гаргах, малын тооллого болон

аж ахуйн нэгжийн тооллого зохион байгуулан явуулах, улмаар мал тооллогын картуудыг өрх, нэгж бүрээр шивж сан үүсгэх, мөн хүн амын анхан шатны бүртгэл болох “ Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр” –ийг аймгийн хэмжээнд бүрэн хөтлүүлж мэдээллийн бааз үүсгэн компьютерт бүрэн шивж цаашдаа өөрчлөлтийг жил, улирал тутам хийж байх нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Одоо тус хэлтсийн ажилтнууд ажлын нэг, нэг компьютертэй, гисон 2000 хувилагч машин ажилдаа ашиглан өндөр хурдны шилэн кабелиар интернетэд холбогдон бүх мэдээллээ асар богино хугацаанд төвд дамжуулахын зэрэгцээ дэлхийн аль ч улс оронтой харьцах өргөн боломжтой болж мэдээллийн бааз, сангуудыг интернетээр хэрэглэгч компьютер, IPAD, IPHONE, гар утаснаасаа ч хэрэгтэй мэдээллээ авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Энэ бүхний үр дүнд мэдээллийг богино хугацаанд боловсруулах, дамжуулах, тархаах боломж бүрдсэн байна. Статистикийн хэлтэс нь одоогоор дарга, эдийн засгийн нэгжийн тооллого, судалгааны ажил эрхэлсэн ажилтан, дэд бүтэц, үйлдвэрлэлийн хүрээний мэдээлэл хариуцсан ажилтан, хүн ам, нийгмийн салбарын мэдээлэл хариуцсан ажилтан, мэдээлэл технологи хариуцсан ажилтан гэсэн үндсэн 5 ажиллагсадтайгаас гадна бусад салбарын мэдээлэл хариуцсан гэрээт ажилтан, Өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний түүвэр судалгааны ажилтан 3, Цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж байгаа байдал судалгааны ажилтан 3, жолооч 1, нийт 13 ажиллагсадтайгаар ажил үүргээ гүйцэтгэж байна.

Статистикийн хэлтэс болон салбарын хүрээнд олон жил идэвхи зүтгэлтэй ажиллаж байсан С. Очирбат, О. Пүрэвдорж, Малчин сумын орлогч дарга Ч. Басан, Давст сумын орлогч дарга Г. Самбуу, Наранбулаг сумын орлогч дарга Х. Дашдаваа, Өмнөговь сумын орлогч дарга Хүрлээ, Зүүнхангай сумын орлогч дарга Дэжидмаа, Завхан сумын орлогч дарга Статистикийн хэлтсийн дарга Ж. Эрдэнэсүрэн, ажилтан А. Батхишиг, Л. Цогтсайхан, Р. Сарантуяа нарын хүмүүс салбарын тэргүүн болох “Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан байна.

“ Бүртгэл Статистикийн тэргүүний ажилтан” цол

тэмдэгтэнгүүд :

1. С. Очирбат 1974 он
2. О. Пүрэвдорж 1984 он
3. Ч. Басан 1984 он

4. Х. Дашдаваа 1994 он
5. Ж. Эрдэнэсүрэн 1994 он
6. Г. Хүрлээ 1994 он
7. Г. Самбуу 1994 он
8. А. Батхишиг 1999 он
9. Б. Дэжидмаа 1999 он
10. Ж. Даваажав 2001 он
11. М. Даваажав 2001 он
12. Ч. Сайнжаргал 2003 он
13. Ц. Бадамдорж 2003 он
14. Б. Дэмчиг 2004 он
15. С. Раднаа 2004 он
16. Х. Намсрай 2005 он
17. Н. Мягмаржав 2005 он
18. Л. Нарантуяа 2006 он
19. Л. Оюун 2006 он
20. Р. Сарантуяа 2007 он
21. Л. Цогтсайхан 2009 он
22. Ё. Цэрэннамжил 2009 он
23. Э. Жанчив 2009 он
24. Б. Доржсүрэн 2009 он
25. Янжин 2009 он
26. Ч. Гүрбадар 2010 он
27. О. Цэрэндорж 2011 он
28. Ц. Гомбосүрэн 2011 он

Мөн статистикийн албанд олон жил нэр их хөдөлмөрөө зориулан ажиллаж ирсэн Б. Доржсүрэн, О. Пүрэвдорж, С. Очирбат, Ё.Цэрэннамжил, Э. Жанчив, С. Цэндээ, Ч. Сүх Очир зэргийн ахмад ажилтнуудаа дурсахын ялдамд бүртгэл статистикийн ажилд амьдралаа зориулж, түүний төлөө зүтгэж явсан О. Пүрэвдорж, Б. Баянсан, С. Очирбат, Ж. Буяндэлгэр, С. Хурц нарын гэгээн дурсгалыг бид ямагт хүндэтгэж явдаг.

Статистикийн товчоо, хэлтсийн даргаар

ажиллаж байсан хүмүүс

1. Д.Лхамжав	1960-1961 он
2. Г.Цэрэнжээ	1961-1965 он
3. Б.Баянсан	1965-1968 он
4. Гомбодорж	1968-1969 он
5. Б.Доржсүрэн	1969-1977 он
6. О.Пүрэвдорж	1977-1987 он
7. Ж.Буяндэлгэр	1987-1988 он
8. А.Батчулуун	1990-1991 он
9. Ж.Эрдэнэсүрэн	1991-ээс хойш одоо хүртэл

Статистикийн хэлтэс, товчоонд ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан хүмүүс


1. Г.Цэрэнжээ	1960-1961 он
2. Г.Ёндонжамц	1961-1963 он
3. Б.Баянсан	1963-1965 он
4. Г.Бямбажав	1965-1968 он
5. Б.Доржсүрэн	1968-1969 он

6. З.Намсрай 1969-1973 он
7. О.Пүрэвдорж 1973-1977 он
8. Ч.СүхОчир 1977-1980 он
9. Е.Цэрэннамжил 1980-1985 он
10. Ж.Буяндэлгэр 1985-1987 он
11. Ж.Эрдэнэсүрэн 1987-1989 он
12. А. Батхишиг




Үндсэн ажиллагсадын 85,7 хувь нь статистикч, эдийн засагч, мэдээлэл технологийн чиглэлээрх мэргэжлийн ажиллагсад байгаа бөгөөд судлаачдын 83.3 хувь нь статистикч эдийн засагч мэргэжлийн ажилтнууд ажиллаж байна.

Статистикч,эдийн засагч мэргэжилтэй ажиллагсдын эзлэх хувь



Ажиллагсадын тоо, ажилласан жилээр, дүнд эзлэх хувиар



Нийт ажиллагсдын 23.1 хувь нь 20-иос дээш жил ажилласан туршлагатай ажиллагсад байгаа бөгөөд 76.9 хувийг 1-10 жил ажилласан залуу ажилчид бүрдүүлж байна.